

**"МОН НООС"**  
**ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН**  
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 11-р сарын  
01-ны өдөр

Дугаар 05/22

Улаанбаатар хот

Их хэмжээний хэлцэл хийх  
зөвшөөрөл олгох тухай

**ТЭМДЭГЛЭХ НЬ:**

"Монноос ХК" –ийн үйл ажиллагаа зогсооноос эхлэн хориод жил "Ариг гол" ХК нь өөрийн хамаг мөнгөө шавхаж тус компанийг санхүүжүүлсэн төдийгүй, Банк болон ББСБ-аас 2.5-3.0%-ийн хүйтэй авсан зээлээсээ МН ХК-д хүүгийн зөрүүг өөрөө дааж бага хүүтэйгээр зээлдүүлсний дээр 543.2 мян.ам.дол-ын зээлийг гадны компаниас зуучиллаар олж зээлдүүлсэн байгаа.

Энэхүү зээлүүдийн хүү нь банк болон ББСБ-ын зээлийн дундач хүүгээс 1.0-1.5%-иар бага хүйтэй олгогдоноос зээлийн хүү, валютын ханшийн зөрүүгээр 4.3 тэрбум.₮-ийн хөнгөлөлтийг Ариг гол ХК нь тус компанийд үзүүлсэн байна

Энэхүү бага хүйтэй зээлийн эх үүсвэрээр Мон ноос ХК-ийн үл хөдлөх хөрөнгийн болон газрын татвар, бусад орлогоос давсан зардлыг санхүүжилснээр тус компани нь өнөөдөр үл хөдлөх хөрөнгийн бүрэн байдал, газар эзэмших эрхээ хадгалж үлдсэнийг онцлон тэмдэглээд:

Монгол улсын "Компанийн тухай хууль"-ийн 88.1 дүгээр зүйл, 89.1 дүгээр зүйл, ТУЗ-ийн 2022 оны 11 дүгээр 01 ны өдрийн хурлын 05/22 тоот тэмдэглэлийн шийдвэрлэсэн нь хэсгийн 1 дүгээр заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Үндэсний ноолуурын салбарын үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд , энэхүү тогтоолд тэмдэглэсэн үндэслэлээр, Монноос ХК-ийн хөрөнгө худалдсаны орлогоос өр төлбөрийг төлөөд үлдсэн чөлөөт үлдэгдлээс 20.0 тэрбум хүртэл хэмжээний зээлийг "Ариг гол" ХК-ийн ноолуур түүхий эд бэлтгэх эргэлтийн хөрөнгийн эх үүсвэрийн зориулалтаар зээлдүүлэхийг гүйцэтгэх захирал (Х.Эрдэнэбаяр)-т зөвшөөрсүгэй.
2. Зээлийн хүүг нэг жилд 6 (зургаан хувь)-иар тогтоосугай.
3. Энэхүү хэлцэл нь их хэмжээний хэлцэл болохын хувьд ТУЗ-ийн бүх гишүүд зөвшөөрсөн, Ариг гол ХК-д ажиллаж байгаа ТУЗ-ийн гишүүд болох Ц.Цэнгэлбаяр, С.Мөнхжаргал нар нь сонирхлын зөрчилтэй гишүүд болохыг тэмдэглэсүгэй.
4. ТУЗ-ийн сонирхлын зөрчилгүй гишүүдийн 100 хувийн саналаар их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрсүгэй.
5. Зээлийн эргэн төлөлтийн графикийн хэрэгжилт, хөрөнгийн эрсдэлгүй байдлыг хяналт удирдлагаар хангаж, ТУЗ-д тухай бүр мэдээлэл оруулж ажлаа тайлагнаж ажиллахыг гүйцэтгэх захирал (Х.Эрдэнэбаяр)-т даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЦЭТГЭГЧ:

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ГИШҮҮН



П.ОЮУНБАЯР

Х.ОЮУНГЭРЭЛ

Л.БҮРЭНТЭГШ

И.СЭР-ОД

С.АЛИМАА

Х.ЭРДЭНЭБАЯР

П.ОЮУНБАЯР